

Улс төрийн философийн орчин үеийн хандлага

Ч.Баатар, магистр багш

Удирдлагын академи, Улсын салбарын удирдлагын тэнхим

Хураангуй: Орчин үеийн улс төрийн философи нь олон талт, интеграцчилсан, технологийн нөлөөллийг нэгтгэсэн, онол ба практикийн уялдааг эрхэмлэсэн шинэлэг чиглэлд хөгжиж байна. Гол үзэл баримтлалууд нь нийтэч либерализм, популизм, постлиберализм, глобал хандлага бөгөөд эдгээр нь уламжлалт онолыг өргөжүүлж, XXI зууны даяаршил, технологи, соёл, жендер, олон улсын нөхцөлд нийцсэн аргачлал, практик хэрэгжилтэд чиглэж байна.

Өгүүллийн хүрээнд орчин үеийн улс төрийн философи нь уламжлалт онолоос хэрхэн ялгаатайгаар хөгжиж байгааг илэрхийлэх оролцлого хийсэн бөгөөд дараах ялгаа, онцлогуудыг тодотгосон. Эдгээр нь 1/Олон талт, интеграцчилсан шинэж; 2/Технологийн нөлөөлөл; 3/Онол ба практикийг уялдаа; 4/Глобал асуудлыг хамарсан интердисциплинар чиглэл зэрэг болно. Энэ нь улс төрийн философийг зөвхөн академик онол биш бодлогын шийдвэр гаргах, иргэдийн оролцоог дэмжих, дэлхийн түвшний тулгамдсан асуудлуудад шийдэл хайх чухал хүрээ болгож байгаа бөгөөд эдгээрийг тухайн өгүүллийн хүрээнд авч үзсэн болно.

Түлхүүр үг: Интеграцчилал, нийтэч либерализм, популизм, постлиберализм, глобал хандлага, хиймэл оюун ухаан, цахим платформ, технологи, нийгэм, эдийн засгийн хөгжил.

Удиртгал

Сүүлийн үед нийгэм, эдийн засгийн хөгжлийн хандлагаас үүдэн улс төрийн философийн уламжлалт онолуудыг шинэ нөхцөлд тохируулан судлах, олон талт хандлагыг нэвтрүүлэх шаардлага нэмэгдсэн (Mouffe, C, 2019). Өмнө нь либерализм, консерватизм, марксизм зэрэг үндсэн сургууль голчлон онолын төвд байсан бол өнөө үед соёл, жендер, угсаатны олон янз байдал, экологи зэрэг олон хүчин зүйлсийг улс төрийн философийн судалгаанд нэгтгэх хандлага давамгайлах болжээ (Dryzek, J. S, 2020).

Энэ нь улс төрийн философийг зөвхөн улс орны дотоод засаглалын хүрээнд бус, глобал асуудлуудын үнэлэх боломжийг нээж байна. Улс төрийн философи нь улс төрийг нийгмийн амьдралын зохион байгуулалттай холбон өргөн дэвсгэр суурин авч үздэг (Баатар Ч, 2010). Үүнээс үүдэн цахим шилжилт, хиймэл оюун, мэдээллийн технологийн хөгжил нь эрх мэдлийн хуваарилалт, иргэний оролцоо, мэдээллийн тэгш бус байдал зэрэг нь уламжлалт онолуудаас гадна цахим платформ дахь ардчиллын илрэл, дата эрх чөлөө ба хариуцлага, алгоритмын нөлөөллийг ойлгох зэрэг философийн судалгааны шинэ чиглэлийг бий болгож байна.

Мөн сүүлийн үеийн чиг хандлагад олон талт үзэл баримтлалын интеграцчилал чухал байр суурь эзэлж байна. “Интеграцчилал” гэдэг нь эдгээр ялгаатай үзэл санаануудыг сөргөлдүүлэх биш, харин хооронд нь зохицуулж, хамт орших боломжийг онолын болон институцийн хувьд бий болгох үйл явц юм. Улс төрийн философид “олон талт үзэл баримтлалын интеграцчилал” гэдэг нь ялгаатай үзэл санаануудын зохицол, уялдаа, хам орших онолын хүрээ юм. Энэ хүрээ нь ардчиллын утга, нийгмийн эв нэгдэл, шударга ёсны тухай ойлголтыг шинэ түвшинд авч үзэх оролдлого гэж хэлж

болно. Энэ хүрээнд улс төрийн философид олон улсын харилцаа, уур амьсгалын өөрчлөлт, глобал эрх зүйн зохицуулалт зэрэг асуудлыг судлах болжээ (Norris, P., Inglehart, R, 2019). Ингэснээр уламжлалт онолуудын хэрэглээ шинэ нөхцөлд өргөжиж, дэлхий нийтийн засаглал, эрх зүйн хариуцлагын харилцан хамаарлыг илүү гүнзгий ойлгох боломж бүрдэж байна. Түүнчлэн постлиберал хандлагын хүрээнд марксизм ба либерализмыг нэгтгэн, иргэдийн оролцооны хэлбэр, эрх мэдлийн шинэ тогтолцоог судлахад чиглэж байна (Mouffe, 2019). Энэ нь онолыг практикт хэрэгжүүлэх, бодлого боловсруулахад илүү чиглэсэн шинж чанарыг төрүүлж, улс төрийн философийн хэрэглээг өргөжүүлсэн гэж хэлж болно. Сүүлийн үеийн судалгаануудад технологийн нөлөөллийг улс төрийн эрх мэдэл, соёлын хүчин зүйлтэй холбож үзэх нь бодит амьдралын сорилтуудыг илүү нарийн тайлбарлах боломжийг өгч байна (Floridi, L, 2021).

Ийнхүү өнөөгийн улс төрийн философийн хөгжлийн гол онцлог нь олон талт, интеграцчилсан, технологийн нөлөөллийг тусгасан, практик болон онолын холболтыг эрхэмлэсэн хандлага болжээ. Энэ нь салбарыг зөвхөн онолын сургууль биш, бодлогын зөвлөмж, ирээдүйн засаглалын стратеги боловсруулахад чухал суурь болгох чиглэлд хөгжиж байгааг илтгэж байна (Held, D, 2020). Тиймээс сүүлийн үеийн улс төрийн философи нь уламжлалт онол, шинэ сорилтуудыг нэгтгэн, ирээдүйн нийгмийн, технологийн, экологийн нөхцөлд нийцүүлсэн ухаалаг, холбогдсон аналитик хүрээ бий болгохыг зорьж байна.

Орчин үеийн улс төрийн философийн онцлог

Орчин үеийн улс төрийн философийн хөгжлийн онцлог нь олон талт, интеграцчилсан, технологи хамааралтай, онол практикыг аль болохоор уялдуулахад чиглэдэг бөгөөд энэ нь уламжлалт улс төрийн философиос зарим ялгааг бий болгодог (Held, 2020). Уламжлалт улс төрийн философи нь ихэвчлэн төрийн эрх мэдэл, бүтэц, засаглалын зарчим, хүний байгалиас заяасан эрх зүй зэрэг тогтсон онолын хүрээнд төвлөрдөг бөгөөд эдгээрийг онолын түвшинд судалдаг. Харин орчин үеийн улс төрийн философийн хөгжлийн хандлага нь эдгээр уламжлалт суурь ойлголтыг технологийн дэвшил, олон нийтийн оролцоо, соёл, жендер, олон улсын харилцаа зэрэг олон хүчин зүйлтэй нэгтгэх замаар судалж, практик хэрэглээтэй илүү их уялдуулах оролдлого хийдэг. Жишээ нь уламжлалт либерализм нь эрх мэдлийн хуваарилалт, хүний эрх, чөлөөт зах зээлийн зарчимд төвлөрдөг бол орчин үеийн нийтгэч либерализм нь иргэдийн оролцоо, жендерийн тэгш байдал, соёлын олон талт байдал, экологийн асуудлыг нэгтгэн авч үздэг (Mouffe, C, 2019). Мөн орчин үеийн популизм, постлиберализм зэрэг нь уламжлалт ардчиллын эрх мэдлийн төвлөрлийг шүүмжлэх замаар технологи, мэдээллийн дэвшил, онлайн оролцоог онол болон практикт нэгтгэж судалдаг.

Технологийн хөгжил, түүнээс үүдэлтэй нөлөөллийг нийгэм, улс төр, эдийн засгийн хөгжилтэй уялдуулан судлах нь орчин үеийн философийн онцлог бөгөөд уламжлалт философиос ялгах гол шалтгаан юм (Floridi, L, 2021). Өнөөгийн нийгмийн хөгжлийн гол хөдөлгөгч хүч нь технологийн дэвшил болжээ. Хиймэл оюун ухаан, дижитал шилжилт, мэдээллийн технологи, биотехнологи, автоматжуулалт зэрэг шинэчлэлүүд нь нийгмийн бүтэц, эдийн засгийн хөгжил, боловсрол, харилцаа холбоо, улмаар хүний амьдралын хэв маягт гүн гүнзгий өөрчлөлт авчирч байна. Технологи нь зөвхөн эдийн засгийн өсөлтийг дэмжих хэрэгсэл бус, харин соёл, улс төр, ёс зүйн үнэт зүйлийн хувьд шинэ сорилт үүсгэж буй нийгмийн хөгжлийн интеграцийн хүчин зүйл юм. Технологийн хөгжлийн хамгийн тод илэрхийлэл нь эдийн засгийн бүтцийн өөрчлөлт юм. Автоматжуулалт болон дижиталчлал нь үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлж,

хөдөлмөрийн бүтээмжийг хурдасгаж байгаа боловч ажил эрхлэлтэд хоёр талт нөлөө үзүүлж байна. Энэ нь нэг талаас шинэ мэргэжил, инновацийн салбаруудыг бий болгож, бүтээлч эдийн засгийг дэмжиж байгаа бол нөгөө талаас уламжлалт хөдөлмөрийн зах зээлийг шахаж, технологийн ялгаа буюу “дижитал анги, давхраажилт”-ыг бий болгож байна гэж үзэж болно. Үүнтэй уялдан нийгмийн дотор мэдээлэлд суурилсан шинэ давхраажилт бий болж, дижитал орчинд оролцох чадвар нь нийгмийн капиталын нэг хэмжүүр болон хувирч байна. Технологийн хүртээмжийн ялгаа нь боловсрол, орлого, амьдралын чанарт нөлөөлж, шинэ хэлбэрийн нийгмийн тэгш бус байдлыг үүсгэх хандлагатай байгаа юм.

Технологийн дэвшил нь нийгмийн соёл, харилцааны хэв маягийг гүн гүнзгий өөрчилж байна. Социал медиа, интернет соёл, виртуал орон зай нь хүмүүсийн харилцах, өөрийгөө илэрхийлэх хэлбэрийг дахин тодорхойлсон нь нэг талаас ардчилсан оролцоо, ил тод байдлыг дэмжиж, олон нийтийн дуу хоолойг хүчирхэгжүүлж байгаа, нөгөө талаас “мэдээллийн хөөсрөлт”, “хуурамч мэдээлэл” зэрэг үзэгдлийг бий болгож, нийгмийн итгэлийн бүтэц, үнэн бодит мэдээллийн ойлголтод сөрөг нөлөө үзүүлж байна. Цаашлаад технологи нь соёлын глобалчлалын гол зэвсэг болж, орон нутгийн үнэт зүйл, уламжлалт харилцааг дэлхийн сүлжээний соёлд уусгах хандлагатай. Энэ үйл явц нь зарим судлаачдын үзэж буйгаар соёлын ижилсэлд хүргэж болзошгүй юм. Технологи нь орчин үеийн нийгмийн хөгжлийг эдийн засаг, соёл, ёс зүй, улс төрийн бүх хүрээнд цогцоор нь өөрчилж буй хамгийн нөлөө бүхий хүчин зүйл юм. Түүний нөлөө нь хоёр талтай бөгөөд нэг талаас хөгжил, инноваци, хүртээмжийг дэмжиж байгаа бол нөгөө талаас тэгш бус байдал, ёс зүйн эрсдэл, соёлын нягтралыг бий болгож байна. Иймээс технологийн хөгжил нь өөрөө зорилго биш, харин хүний хөгжлийн чанарын хэмжүүртэй уялдах ёстой. Орчин үеийн нийгэмд технологийн нөлөөллийг зөв удирдах нь зөвхөн шинжлэх ухааны асуудал бус, харин улстөрийн философи, ёс зүйн хариуцлагын асуудал юм. Түүнчлэн хиймэл оюун, их өгөгдөл, блокчейн, цахим санал асуулгын платформууд нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, бодлогын үр нөлөөг урьдчилан таамаглах, засаглалын ил тод байдлыг сайжруулах боломжийг олгодог. Энэ нь уламжлалт философийн онолоос ялгаатай нь зөвхөн эрх мэдлийн хуваарилалт, институцийн бүтэцийг судлах биш, технологийн нөлөөллийг бодит практикт нэгтгэж байгаа явдал юм. Гэсэн хэдий ч, орчин үеийн философи нь зарим сорилтуудтай тулгарч байна. Жишээ нь технологийн төвлөрөл, алгоритмын ил тод бус байдал, мэдээллийн тэгш бус байдал, олон улсын болон үндэсний эрх зүйн зөрчил зэрэг асуудлууд нь орчин үеийн философийн практик хэрэгжилтэд хүндрэл учруулдаг. Мөн зарим шүүмжлэгчид орчин үеийн улс төрийн философийг “хэт төвөгтэй, олон хэмжээст” гэж үзэн, уламжлалт философийн энгийн, системчилсэн онолуудтай харьцуулахад ойлгоход хэцүү хэмээн шүүмжилдэг.

Хүснэгт 1. Орчин үеийн ба уламжлалт улс төрийн философийн ялгаа

Үзэл баримтлал	Онцлог	Улс төрийн философи онолууд	Давуу тал	Шүүмжлэл
Уламжлалт улс төрийн философи	Эрх мэдэл, төрийн бүтэц, засаглалын зарчим, хүний эрх, онолын төвлөрсөн судалгаа	Либерализм, Консерватизм, Социализмын уламжлалт онолууд	Онолын системчилсэн бүтэц, ойлгоход энгийн, батлагдсан суурь онолууд	Технологийн нөлөөллийг дутуу авч үздэг, бодит амьдралын сорилтод хангалттай нийцдэггүй
Орчин үеийн улс төрийн философи	Олон талт, интеграцчилсан, технологийн нөлөөлөл, онол, практикийн харилцан уялдаа	Нийтэч либерализм, Популизм, Постлиберализм, Глобал хандлага	Олон үзэл баримтлал, технологийн нөлөөллийг интеграцчилж судлах, бодлогын практикт холбох боломж	Олон хэмжээст, төвөгтэй, заримдаа ойлгоход хэцүү, технологийн төвлөрөл, алгоритмын ил тод бус байдал зэрэг сорилт үүсдэг

Орчин үеийн улс төрийн философийн хөгжлийн гол ялгаа нь олон талт шинжилгээ, технологийн интеграцчлал, онол болон практикийн уялдаа холбоо зэрэгт оршиж, уламжлалт философийн зөвхөн онолын төвлөрсөн хандлагыг бодит нийгмийн сорилтод нийцүүлэх байдлаар өргөжүүлж байгаа юм. Энэ нь улс төрийн философийг зөвхөн онолын сургалт бус, бодлого боловсруулах, иргэний оролцоог үнэлэх, засаглалын ил тод байдлыг сайжруулах чиглэлд ашиглах боломжийг нэмэгдүүлж байна.

Улс төрийн философийн сүүлийн үеийн хөгжлийн хандлагыг илэрхийлж буй зарим үзэл баримтлалууд

Сүүлийн арван жилд улс төрийн философид олон талт, интеграцчилсан чанартай шинэ үзэл баримтлалуудын нэг нь нийтэч либерализм (Communitarian liberalism эсвэл liberal communitarianism) юм.

Орчин үеийн улс төрийн философид либерализм ба коммунитаризм хоёр нь хүний эрх чөлөө, нийгмийн хамтын үнэ цэнийн хоорондын харилцааг тайлбарлах хоёр гол урсгалд тооцогддог. Либерализм нь хувь хүний автономит байдал, эрх чөлөө, шударга ёсыг нийгмийн байгууллын суурь гэж үздэг бол коммунитаризм нь хүнийг нийгмийн оролцоонд суурилсан, хамтын үнэт зүйлээр тодорхойлогдох оршихуй гэж ойлгодог (Etzioni, A, 1995). Энэ хоёр үзэл баримтлалын зөрчил болон харилцан уялдаа нь XX зууны сүүлч үеэс философийн томоохон маргааны сэдэв болсон бөгөөд үүнээс “нийтэч либерализм” буюу “communitarian liberalism” хэмээх холбоос үүссэн гэж хэлж болно.

Либерализмын уламжлал нь Жон Локк, Иммануэл Кант, Жон Стюарт Милл зэрэг сэтгэгчдийн бүтээлд үндэслэж, хувь хүний эрх, хууль ёсны эрх чөлөө, төрийн төвийг сахих байр суурийг онцолдог (Rawls, J, 1971).

АНУ-ын философич Жон Роулзын 1971 онд анх хэвлүүлсэн “Зүй ёсны онол (A Theory of Justice)” бүтээл нь либерализмыг “зүй ёсны онол”-оор баталгаажуулж, хувь хүний эрх чөлөөг нийтлэг сайн сайхныг хангах зарчмын дагуу хамгаалах үндэслэл боловсруулсан. Харин коммунитаризм нь либерализмын энэхүү “хэт хувь хүнд төвлөрсөн” хандлагыг шүүмжилж, хүнийг нийгмийн соёл, хамтын үнэт зүйлийн орчинд “суулгасан (embedded)” оршихуй гэж үзсэн (Taylor, C, 1994). Коммунитаристуудын үзлээр, хувь хүний үнэт зүйл, сонголт, эрх чөлөө нь нийгмийн хамтын туршлага, уламжлал, соёлын хүрээнд л бүрэн утга олдог. Нийтэч либерализм нь эдгээр хоёр үзлийн интеграцчилсан хэлбэр бөгөөд либерализмын хувь хүний эрх чөлөөг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ коммунитаризмын хамтын хариуцлага, нийгмийн оролцооны ач холбогдлыг уялдуулахыг зорьдог (Etzioni, A, 1998). Энэхүү хандлага нь “We society” буюу хамтын оролцоонд тулгуурласан либерализмыг хөгжүүлэхийг эрмэлздэг бөгөөд нийгмийн ёс зүй, иргэний хариуцлагыг эрх чөлөөний оршин тогтнох үндсэн нөхцөл гэж үздэг.

Энэхүү үзэл санааны гол төлөөлөгч Израиль гаралтай АНУ-ын философич, социологич Амитаи Этциони (Amitai Etzioni)-гийн бичсэн “Хамтын ухамсрын хүч (The Spirit of Community)” (1993) болон “Шинэ алтан дүрэм: Ардчилсан нийгэм дэх хамтын ёс зүйн үнэт зүйл (The New Golden Rule: Community and Morality in a Democratic Society)” (1998) бүтээлүүдээ эрх чөлөө ба хариуцлагын тэнцвэр дээр суурилсан нийгмийн философийг дэвшүүлсэн. Түүний үзлээр, орчин үеийн ардчилсан нийгэмд иргэний эрхийн зэрэгцээ иргэний үүрэг, ёс суртахууны хариуцлагыг сэргээх нь чухал бөгөөд энэ нь либерализмын суурийг бэхжүүлнэ гэж үзсэн.

Нийтэч либерализмд чиглэсэн судлаачдын шүүмжлэл нь хоёр үндсэн чиглэлтэй байдаг. Нэгдүгээрт, зарим либерал онолчид үүнийг эрх чөлөөний хязгаарлалтыг зөвтгөж болзошгүй хэмээн шүүмжилдэг (Galston, W. A, 1991). Хоёрдугаарт, зарим коммунитаристууд үүнийг коммунитаризмын философийг зөөлрүүлсэн, либерализмын хүрээнд баригдсан хувилбар гэж үздэг (Sandel, M. J, 1998). Гэсэн ч олон судлаачийн үзэж байгаагаар энэ онол нь орчин үеийн ардчилсан нийгмийн ёс зүйн болон соёлын интеграцийн практик хувилбар болж чадсан юм.

Нийтэч либерализм нь орчин үеийн улс төрийн философид хувь хүн ба нийгмийн харилцааны тухай маргааныг холбох онол болж гарч ирсэн. Энэ нь либерализмын эрх чөлөөний үзэл санааг хадгалж, коммунитаризмын хамтын хариуцлагын үнэт зүйлтэй уялдуулснаараа илүү бодит, ёс суртахуунлаг ардчиллын суурийг тавих зорилготой гэж үзэж болно. Энэ нь XXI зууны даяаршсан, ёс зүйн олон талт нийгэмд энэ хандлага нь эрх чөлөө, хариуцлага, хамтын оршихуйн зохицлыг онолын түвшинд ойлгох чухал хүрээ болж байна. Гэсэн хэдий ч зарим шүүмжлэгчид нийтэч либерализмыг илүү төвлөрсөн эрх мэдлийн асуудлыг шийдэхэд хангалтгүй, эрх мэдлийн үл тэнцвэрийн асуудлыг бүрэн дүүрэн хамаардаггүй гэж үздэг байна. Нөгөөтэйгүүр, популист улс төрийн философи (populist political philosophy) нь сүүлийн үеийн сорилтууд, тухайлбал, ардчиллын тухай асуудал, нийгмийн дээд давхраа ба олон нийтийн хоорондын зөрчил, нийгмийн шударга ёсны асуудлыг шинэ өнцгөөс судлахад чиглэгдэж байна (Mouffe, C, 2019).

Популист улс төрийн философи нь олон нийтийн санаа бодлыг үндсэн судлагдахуунаа болгон, уламжлалт онолын эрх мэдлийн төвлөрсөн бүтэц, институцийн нөлөөг шүүмжилдэг. Жишээ нь Латин Америкийн зарим улс орнуудад популист хөдөлгөөн

нь уламжлалт парламентын тогтолцоог тойрон, иргэдийн шууд оролцоог дэмжих замаар засаглалын шинэ хэлбэрийг туршиж байна. Гэсэн ч, популист улс төрийн философи нь заримдаа үндсэн эрх зүйн зарчмуудыг үл тоомсорлодог, олон нийтийн эрх ашгийг хэт дөвийлгөн авч үздэг гэх шүүмжлэлд өртдөг.

Мөн постлиберализм (post-liberalism) нь уламжлалт либерализмын хязгаарлалт, эдийн засаг, эрх зүйн харилцан хамаарлыг илүү гүнзгий судлах замаар улс төрийн онолыг шинэчилж байна. Постлиберализм нь технологийн хөгжил, мэдээллийн эрх чөлөө, дата болон алгоритмын нөлөөллийг улс төрийн философийн шинжилгээнд нэгтгэж, ирээдүйн засаглалын шинэ схемийг тодорхойлоход хувь нэмэр оруулдаг. Жишээлбэл, иргэдийн улс төрийн саналыг цахим байдлаар цуглуулах, санал авахад чиглэсэн платформууд, хиймэл оюун ба автоматжуулсан шийдвэр гаргалт нь постлиберализмын онолыг бодит нөхцөлд хэрэгжүүлж буй туршилтууд юм. Гэсэн хэдий ч, шүүмжлэгчид постлиберализмыг практикт хэрэгжүүлэхэд технологийн төвлөрөл, хяналтын асуудлыг дутуу авч үздэг гэж үздэг.

Глобал хандлага (cosmopolitanism) буюу космополитизм нь хүн төрөлхтнийг үндэсний хил, угсаа, шашин, соёлын ялгаанаас ангид, нэгэн нийтлэг ёс зүй, улс төрийн хамтын нийгэмлэг болгон ойлгох үзэл баримтлал юм (Appiah, K. A, 2006). Космополитизм нь эртний Грекийн Стоицизмын уламжлалаас үүдэлтэй боловч орчин үеийн даяаршсан нийгмийн нөхцөлд дахин сэргэж, иргэншлийн хүрээг улс хоорондын хязгаараас давсан дэлхийн иргэншлийн ёс зүйн онол болон хөгжжээ. Космополитизмын үндэс нь эртний Грекийн философич Сократ, Диоген, Стоикуудын “cosmopolites” буюу “дэлхийн иргэн” гэсэн үзэл санаанаас үүдэлтэй гэж үздэг. Философич Диоген Лаэртус “Би Афин хүн биш, дэлхийн иргэн” гэж тунхагласнаар тухайн үеийн хот улсын (polis) хязгаарыг давсан ёс зүйн нийтлэг ухамсрын санааг илэрхийлжээ (Nussbaum, M. C, 1997).

Германы философич Иммануэл Кант 1795 онд анх хэвлүүлсэн “Мөнхийн энх тайван (Perpetual Peace)” бүтээлдээ дэлхийн иргэний эрх (cosmopolitan right) гэсэн ойлголтыг гаргаж ирж, энх тайвныг үндэстэн хоорондын гэрээ бус, харин хүн төрөлхтний нийтлэг ёс зүйн үүрэг гэж тодорхойлсон. Энэ санаа нь орчин үеийн космополитизмын философийн суурь үзэл санаа юм. Харин ХХ зууны сүүлээс эхлэн дэлхийн харилцан хамаарал, хүний эрхийн нэгдсэн ойлголт, олон улсын хууль, даяаршлын эрчимжилт зэрэг нь космополитизмын үзэл санааг улс төрийн философийн төвд дахин авчирсан юм (Beck, U, 2006).

Космополитизм нь онолын хувьд ёс зүйн хувьд төгс мэт боловч бодит улс төрийн түвшинд хэрэгжүүлэхэд олон бэрхшээлтэй байдаг. Үндэстний тусгаар тогтнол, соёлын ялгаа, улс төрийн эрх ашиг нь “дэлхийн иргэншил”-ийн үзэлтэй зөрчилддөг (Miller, D, 2007). Түүнчлэн глобал капитализм, корпорацийн эрх мэдэл, геополитикийн тэгш бус байдал нь космополит ёс зүйг практикт хэрэгжүүлэхэд саад болдог байна. Зарим шүүмжлэгчид космополитизм нь үндэсний онцлог, соёлын үнэт зүйлсийг үл тоомсорлох хандлагатай, хэт ерөнхийлсөн утга агуулгатай хэмээн үздэг. Гэсэн ч түүний дэвшүүлсэн глобал шударга ёс, хүн төрөлхтний хариуцлагын үзэл санаа нь ХХI зууны улс төрийн философийн хөгжлийн чухал чиглэл хэвээрээ байна.

Космополитизм нь бие даасан философийн хандлага, ёс зүйн болон улс төрийн онолын чиглэл болохынхоо хувьд либерализм, коммунитаризм, реализм зэрэг уламжлалт онолуудаас ялгаатайгаар дэлхийн түвшний иргэншлийн үнэт зүйлийг онолын төвд тавьдаг. Хэдийгээр түүний үзэл санаа либерал ёс зүйн универсализмаас санаа авсан ч, космополитизм нь илүү өргөн хүрээнд хүн төрөлхтний нийтлэг үүрэг, дэлхийн засаглал, иргэний хамтын хариуцлага зэргийг хамардаг. Иймээс энэ нь орчин

үеийн улс төрийн философийн бие даасан, нэг салбарын хүрээнд бус, олон салбарын мэдлэг, арга зүйг холбосон буюу интердисциплинар чиглэл гэж тооцогддог. Орчин үеийн улс төрийн философийн глобал хандлага буюу космополитизм нь хүн төрөлхтнийг үндэсний хил, соёлын ялгаанаас ангид нийтлэг ёс зүйн нэгдэл гэж үзэх онол юм. Энэ үзэл нь Кантын энх тайвны талаарх философийн үзэл баримтлалаас эх авч, XXI зууны даяаршсан ертөнцийн нөхцөлд глобал шударга ёсны болон дэлхийн иргэний хариуцлагын асуудлыг онолын төвд авчирсан юм. Космополитизм нь төгс төгөлдөр ертөнцийн төсөөлөл бус, харин дэлхий нийтэд тулгараад буй ёс зүйн сорилт, нийгмийн хариуцлагыг ухамсарлах бие даасан философийн үзэл баримтлал гэж үзэж болно.

Глобал хандлага нь улс төрийн бие даасан философийн үзэл баримтлал бус, бодлогын шийдвэр гаргахад холбогдох аналитик хүрээ болон хөгжиж байна. Жишээ нь олон улсын уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хийгдсэн гэрээнүүд, гадаад харилцааны эрх зүйн шинэ загварууд глобал хандлагыг практикт хэрэгжүүлж буй жишээнүүд юм. Гэсэн хэдий ч, зарим шүүмжлэгчид глобал хандлагыг үндэсний засаглалын хүчирхэг эрх мэдлийг сулруулж болзошгүй гэж анхааруулдаг.

Эндээс үзэхэд сүүлийн үеийн улс төрийн философийн хөгжлийн гол үзэл баримтлал нь дээр дурьдсан нийтэч либерализм, популист улс төрийн философи, постлиберализм, глобал хандлага буюу космополитизм гэсэн дөрвөн чиглэлээр илэрхийлэгдэж байна. Эдгээр үзэл баримтлал нь уламжлалт онолыг өргөжүүлэх, технологи, соёл, жендер, олон улсын харилцааны нөлөөллийг нэгтгэн судлах замаар улс төрийн философийн практик болон онолын хэрэгцээг хангаж байна. Тиймээс улс төрийн философи нь зөвхөн онолын сургалт бус, бодит нийгмийн сорилтод нийцүүлсэн шинэлэг, холбогдсон аргачлал болгон хөгжиж буйг харуулж байна. Эдгээр нь уламжлалт онолуудыг өргөжүүлж, олон талт, интеграцчилсан шинж чанартай болсон бөгөөд нийтэч либерализм, популизм, постлиберализм, глобал хандлага гэсэн үзэл баримтлалууд нь өөр өөр онолын суурь, практик хэрэглээ, технологийн интеграцлалын түвшингээр ялгардаг.

Хүснэгт 2. Орчин үеийн улс төрийн философийн гол үзэл баримтлалын харьцуулалт

Нэр	Гол ойлголт	Онцлог	Жишээ	Давуу тал	Шүүмжлэл
Нийтэч либерализм	Иргэний эрх, жендер, соёлын олон талт байдал, экологийн асуудал	Эрх мэдлийн төвлөрлийг сааруулах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх	Европын холбооны орон нутгийн засаглал, жендерийн эрх тэгш байдлын бодлого	Олон нийтийн оролцоог дэмждэг, олон талт үнэт зүйлсийг нэгтгэдэг	Зарим тохиолдолд эрх мэдлийн төвлөрлийг бүрэн шийдэж чадахгүй
Популист улс төрийн философи	Элит ба олон нийтийн хоорондын зөрчил, шууд ардчилал	Иргэдийн шууд оролцоог дэмжих, элитийн төвлөрлийг шүүмжлэх	Латин Америкийн популист хөдөлгөөнүүд, цахим санал асуулга	Иргэдийн оролцоог идэвхжүүлдэг	Заримдаа үндэсний эрх зүйн зарчмыг үл тоомсорлох, хэт туйлширсан авч үздэг
Постлиберализм	Уламжлалт либерализмын хязгаарлалыг судлах, технологийн нөлөөллийг нэгтгэх	Алгоритм, хиймэл оюун ухаан, цахим оролцоог онол ба практикт холбох	Хиймэл оюун ухаанд суурилсан платформууд	Технологийн сорилтод нийцсэн интеграцчилсан шинжилгээ	Алгоритмын төвлөрөл, мэдээллийн тэгш бус байдал, хяналтын дутагдалтай
Глобал хандлага	Дэлхийн хэмжээний асуудал, олон улсын эрх зүй, уур амьсгал	Улс орны хязгаарлалтыг давж, дэлхийн хэмжээний бодлогыг судлах	Олон улсын уур амьсгалын гэрээ, гадаад харилцааны эрх зүйн шинэ загварууд	Дэлхийн хэмжээний асуудлыг судлах боломжтой	Үндэсний засаглалын хүчийг сулруулж болзошгүй, практик хэрэгжилтэд төвөгтэй

Эдгээр дөрвөн үзэл баримтлал нь хоорондоо онолын суурь, технологийн интеграцчлал, практик хэрэглээний түвшингээр ялгаатай боловч орчин үеийн улс төрийн философийн хөгжлийг тодорхойлдог гол чиглэлүүд юм. Интеграцчилсан шинж чанар, олон талт задлан шинжилгээ, онол ба практикийн уялдаа холбоо зэрэг нь уламжлалт философиос ялгагдах гол онцлог болон улс төрийн философийг улс орнуудын төрийн бодлогын, технологийн хөгжлийн үйл явцад нийцүүлэх оролдлого хийгдэж эхлээд байна.

Орчин үеийн улс төрийн философийн хөгжлийн олон талт, интеграцчилсан хандлага

Орчин үеийн улс төрийн философийн хөгжлийн хамгийн тодорхой онцлог нь олон талт, интеграцчилсан шинж чанар юм. Энэхүү хандлага нь уламжлалт онолуудыг нэг талаас бататгах, нөгөө талаас технологийн, соёлын, экологийн болон олон улсын сорилтуудыг шинжлэх ухааны болон практик хэрэглээнд нэгтгэхийг зорьдог (Dryzek, J. S, 2020). Жишээ нь нийтэч либерализм нь олон нийтийн оролцоо, жендерийн болон угсаатны олон янз байдал, экологи, эдийн засгийн эрх тэгш байдлыг нэгтгэн авч үздэг. Энэ нь улс төрийн философийг зөвхөн засаглалын онолын түвшинд бус, бодлогын хэрэгжилт, иргэдийн оролцооны бодит боломжтой холбодог.

Интеграцчилсан хандлага нь улс төрийн олон чиглэлийн ойлголтыг нэгтгэж, онолын төгсгөлд практик хэрэгцээтэй холбодог. Тухайлбал, глобал хандлага (cosmopolitanism) нь улс орны эрх зүйн хүрээ, засаглалын хязгаарлалт, олон улсын эрх зүйн зохицуулалт, уур амьсгалын өөрчлөлт зэрэг олон түвшний асуудлыг нэгэн үзэл баримтлалд нэгтгэн судлах боломжийг олгодог. Энэ нь улс төрийн философийн уламжлалт сургалтын хүрээг дэлхийн хэмжээний бодлогын асуудалтай холбож, олон талт шинжилгээний хүрээ бий болгодог.

Орчин үеийн технологийн хөгжлийг судалгааны төвд авчирсан нь орчин үеийн философийн интеграцчилсан шинж чанарыг тодотгодог. Жишээ нь хиймэл оюун ухаан, алгоритмын шийдвэр гаргалт, цахим орчин дахь иргэний оролцоо зэрэг нь улс төрийн эрх мэдлийн хуваарилалт, мэдээллийн тэгш бус байдал, нууцлалын асуудал зэрэг нь судалгаа, шинжилгээний шинэ аргачлалыг шаардаж байна. Энэ нь уламжлалт либерализмын хязгаарлалтыг даван туулж, улс төрийн философийг шинэ сорилтуудын хүрээнд өргөжүүлэх боломжийг нээн өгч байна.

Олон талт, интеграцчилсан хандлагын нэг чухал шинж чанар нь онол болон практикийг уялдуулах явдал юм. Тухайлбал, популизм ба постлиберализмын онолуудыг судалж, тэдгээрийг бодит засаглалын механизм, иргэний оролцооны шинэ хэлбэртэй уялдуулах нь улс төрийн философийг зөвхөн онолын сургалт бус, бодлогын хэрэгжилтэд шууд нөлөө бүхий практик хүрээ болгож байна. Гэсэн хэдий ч, энэхүү интеграцчилсан хандлага нь заримдаа эрх мэдлийн төвлөрөл, технологийн эрх мэдлийн хяналт, олон улсын болон үндэсний эрх зүйн зөрчил зэрэг асуудлыг бүрэн шийдэж чадахгүй гэсэн шүүмжлэлтэй тулгардаг.

Нөгөө талаас, олон талт хандлага нь соёлын, жендерийн, угсаатны олон янз байдалд анхаарал хандуулах замаар уламжлалт эрх мэдлийн ойлголтыг өргөжүүлдэг. Жишээлбэл, Европын холбооны орнууд дахь иргэний оролцоо, орон нутгийн засаглалын шинэ хэлбэрүүд нь нийтэч либерализмын үзэл баримтлалд нийцсэн туршилтуудыг харуулж байна. Гэсэн хэдийн ч зарим шүүмжлэлүүд нь олон талт хандлагыг бодит эрх мэдлийн хуваарилалтыг өөрчлөхөд хангалтгүй, институцийн төвлөрлийг бууруулж болзошгүй гэж үздэг.

Хүснэгт 3. Орчин үеийн улс төрийн философийн хөгжлийн олон талт, интеграцчилсан онцлог: Үзэл баримтлалуудын харьцуулалт

Үзэл баримтлал	Тайлбар	Жишээ	Давуу тал	Шүүмжлэл
Нийтэч либерализм (Pluralist Liberalism)	Улс төрийн оролцоо, жендер, угсаатны олон янз байдал, экологи зэрэг хүчин зүйлсийг төвд авч үздэг	Европын холбооны орон нутгийн засаглалын шинэ хэлбэрүүд	Олон нийтийн оролцоог дэмждэг, олон талт үнэт зүйлсийг нэгтгэдэг	Эрх мэдлийн төвлөрлийг бүрэн шийдэж чадахгүй, зарим институцийн хязгаарлалтыг үл тоомсорлодог
Популист улс төрийн философи (Populist Political Philosophy)	Ардчиллын илтгэл, элит ба олон нийтийн хоорондын зөрчилд төвлөрдөг	Латин Америкийн популист хөдөлгөөнүүд	Иргэдийн шууд оролцоог нэмэгдүүлдэг, элитийн төвлөрлийг шүүмжилдэг	Үндсэн эрх зүйн зарчмыг үл тоомсорлох эрсдэлтэй, олон нийтийн эрх ашгийг хэт их дөвийлгөдөг
Постлиберализм (Post-Liberalism)	Уламжлалт либерализмын хязгаарлалтыг гүнзгий судалж, технологийн нөлөөллийг нэгтгэдэг	Онлайн платформ дахь ардчиллын механизм, хиймэл оюун ба автоматжуулсан шийдвэр гаргалт	Технологийн шинэ сорилтуудыг судалж, ирээдүйн засаглалын схемийг тодорхойлдог	Технологийн төвлөрөл, хяналтын асуудлыг бүрэн шийдэж чадахгүй
Улс төрийн философи дахь глобал хандлага (Cosmopolitanism)	Улс орны эрх зүйн хүрээний гаднаас дэлхийн нийтийн асуудлыг судална	Олон улсын уур амьсгалын гэрээ, гадаад харилцааны эрх зүйн шинэ загварууд	Дэлхийн хэмжээний асуудлыг судлах боломжтой, олон улсын бодлоготой холбогддог	Үндэсний засаглалын хүчийг сулруулж болзошгүй, зарим тохиолдолд практик хэрэгжилтэд саад учруулдаг

Ийнхүү орчин үеийн улс төрийн философийн хөгжлийн олон талт, интеграцчилсан онцлог нь олон үзэл баримтлал, технологийн хөгжлийг судлах, олон улсын болон үндэсний асуудлыг нэгтгэх, онол ба практикийг уялдуулах гэсэн шинж чанаруудыг нэгтгэдэг. Энэ нь улс төрийн философийг зөвхөн онолын сургууль бус, бодлогын шийдвэр гаргахад хэрэгцээтэй, дэлхийн хэмжээний асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн аналитик хүрээ болгон хөгжүүлж байна. Гэсэн хэдий ч, интеграцчилсан хандлагын

хэрэгжилт нь эрх мэдлийн төвлөрөл, технологийн хяналт, олон улсын болон үндэсний эрх зүйн зөрчил зэрэг сорилтуудтай тулгарсаар байгаа нь ихээхэн шүүмжлэлд өртдөг.

Орчин үеийн улс төрийн философи дахь технологийн нөлөөллийн асуудал

Орчин үеийн улс төрийн философийн хөгжлийн гол онцлогийн нэг нь технологийн нөлөөллийг системтэйгээр интеграцчилан судлах явдал юм. Өнөө үед хиймэл оюун, автоматжуулсан шийдвэр гаргалт, их өгөгдөл, цахим платформ зэрэг технологийн дэвшил нь засаглалын бүтэц, иргэний оролцоо, эрх мэдлийн хуваарилалт, мэдээллийн тэгш бус байдалд гүнзгий нөлөө үзүүлж байна.

Улс төрд үзүүлж байгаа технологийн нөлөөллийг судлах нь практикт чухал ач холбогдолтой байдаг. Жишээ нь иргэдийн улс төрийн сонирхлыг судалдаг цахим платформууд нь иргэдэд хязгаарлагдмал нөхцөлд санал бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргах боломжийг олгодог ба энэ нь популист улс төрийн философи болон нийтэч либерализмын үзэл баримтлалд тулгуурласан шинэ засаглалын хэлбэрийг практикт турших бололцоог олгож байна. Гэсэн хэдий ч эдгээр технологи нь мэдээллийн тэгш бус байдал, алгоритмын хэт төвлөрөл, мэдээллийн эрх чөлөөг хязгаарлах эрсдэлийг агуулж байдаг бөгөөд энэ нь постлиберализмын онолыг бодит байдал дээр хэрэгжүүлэхэд төвөг учруулж байна гэж үздэг.

Мөн хиймэл оюун ба автоматжуулалт нь улс төрийн эрх мэдлийн хуваарилалтыг дахин тодорхойлж, засаглалын төвлөрлийг өөрчлөх боломжийг олгож байна. Тухайлбал, дэлхийн өндөр хөгжилтэй орнууд дахь цахим платформын туршилтууд нь хиймэл оюун ухаанд тулгуурласан мэдээллийн боловсруулалт, иргэдийн саналын системийг ашиглан засаглалын үйл явцыг хөнгөвчлөхөд чиглэж байна. Гэсэн хэдий ч эдгээр платформууд нь алгоритмын нууцлал, алгоритмын ялгаварлан гадуурхалт (Algorithmic Bias), мэдээллийн тэгш бус байдал зэрэг олон сорилтыг араасаа дагуулж байна. Ялангуяа алгоритмын ялгаварлан гадуурхалт нь орчин үеийн хиймэл оюун ухаан ба мэдээллийн технологийн хөгжлийн гол тулгамдсан асуудал болоод байна. Энэ нь өгөгдлийн тэгш бус байдал, загварын дизайн, хүний ухамсаргүй үйлдэл буюу хүний ухамсар, мэдрэмжийн түвшинд бүрэн ухамсарлагдаагүй, ойлгоогүй мөртлөө автомат болон идэвхгүйгээр нөлөөлдөг үнэлэмж, урьдчилсан дүгнэлтээс үүдэлтэй бөгөөд нийгмийн шударга ёс, эрх тэгш байдалд шууд нөлөөлдөг. Иймээс алгоритмын зохион байгуулалт, боловсруулалт, хэрэглээнд ил тод байдал, ёс зүйн хяналт, олон талт өгөгдөл шаардлагатай бөгөөд энэ нь зөвхөн техник асуудал бус, нийгмийн философи, ёс зүйн асуудал болж байна.

Технологийн нөлөөлөл нь мөн иргэний эрх, төрийн хяналт, бүх төрлийн хариуцлагын асуудлыг нягтлан үзэх шаардлагыг нэмэгдүүлж байна. Жишээ нь блокчейн технологи нь санхүү, тэтгэмжийн систем, төрийн үйлчилгээний ил тод байдлыг нэмэгдүүлэх боломжийг олгодог боловч түүний боловсруулалт, хяналт, зохицуулалтын хэрэгжилт нь улс төрийн философийн хөгжилд шинэ хандлагыг бий болж байна. Энэ нь технологийн дэвшлийг улс төрийн философийн хүрээнд интеграцчилан судлах шаардлагыг улам их нэмэгдүүлж байгаа юм.

Хүснэгт 4. Орчин үеийн улс төрийн философийн технологийн нөлөөлөл

Технологи	Нөлөөлөл	Жишээ	Давуу тал	Шүүмжлэл
Хиймэл оюун ухаан (AI)	Иргэдийн оролцоо, шийдвэр гаргалт, алгоритмын хяналт	Цахим саналын платформ	Шийдвэр гаргалтыг хөнгөвчлөх, ил тод байдлыг нэмэгдүүлэх	Алгоритмын ялгаварлан гадуурхалт, мэдээллийн тэгш бус байдал, нууцлалын эрсдэл
Их өгөгдөл (Big Data)	Улс төрийн бодлогын шинжилгээ, иргэдийн хандлагыг тодорхойлох	Сонгуулийн стратеги, нийтийн санал судалгаа	Иргэдийн хандлагыг нарийн судлах, бодлогын үр нөлөөг урьдчилан таамаглах	Хувийн мэдээллийн эрх чөлөө, мэдээллийн төвлөрөлд эрсдэл үүсгэх
Иргэдийн улс төрийн санаа бодлыг судлах, санал авахад чиглэсэн цахим платформууд	Шууд оролцоо, санал асуулга, иргэдийн оролцоо	Европын холбооны онлайн оролцоо, Латин Америкийн туршилтууд	Иргэдийн шууд оролцоог нэмэгдүүлэх, засаглалын ил тод байдлыг сайжруулах	Мэдээллийн тэгш бус байдал, алгоритмын төвлөрөл, хяналт сул байх эрсдэл
Блокчейн технологи	Засгийн газрын үйлчилгээ, ил тод байдал, хяналт	Санхүүгийн болон тэтгэмжийн систем, төрийн үйлчилгээ	Ил тод, хяналттай, найдвартай систем	Хөгжлийн түвшин хязгаарлагдмал, зохицуулалт, техник хангамжийн асуудал

Орчин үеийн улс төрийн философи нь технологийн нөлөөллийг судлахдаа олон талт шинжилгээ, онол болон практикийн харилцан уялдаа, эрх мэдлийн шинэ тогтолцоог ойлгох, иргэний оролцоог нэмэгдүүлэх зэрэг асуудлыг нэгтгэн судалдаг. Гэсэн хэдий ч, технологийн төвлөрөл, алгоритмын ялгаварлан гадуурхалт, олон улсын болон үндэсний эрх зүйн зөрчил зэрэг сорилтууд нь энэхүү интеграцчилсан хандлагын хэрэгжилтийг хязгаарлаж байна. Ингэснээр улс төрийн философи нь зөвхөн онолын асуудал бус, улс төрийн бодит амьдрал дахь асуудлуудыг технологийн дэвшилтэй уялдуулсан, шинэлэг, холбогдсон аналитик хүрээ болж хөгжиж буйг харуулж байна.

Улс төрийн философийн хүрээнд технологийн нөлөөллийг судлахад олон талт шинжилгээг ашиглах нь

Орчин үеийн улс төрийн философид технологийн нөлөөллийг судлахад олон талт шинжилгээ (multidimensional analysis) нь гол аргачлалын нэг болж байна. Энэ аргачлал

нь технологийн дэвшил, жишээ нь хиймэл оюун ухаан, их өгөгдөл, иргэдийн улс төрийн санаа бодлыг судлах, санал авахад чиглэсэн цахим платформууд, блокчейн зэрэг элементүүдийн улс төр, нийгэм, эрх зүй, соёлын нөлөөллийг нэгэн зэрэг судлах боломжийг олгож байна. Ингэснээр технологийн хөгжлийг зөвхөн нэг чиглэлээс буюу техникийн эсвэл эдийн засгийн үзлээс бус, бодит нийгмийн болон улс төрийн үр нөлөөг харгалзан үнэлэх боломжтой болно.

Олон талт шинжилгээний гол үзэл баримтлал нь онол ба практикийн уялдаа холбоо юм. Энэ нь технологийн нөлөөллийг зөвхөн онолын хувьд тайлбарлахгүй, харин засаглалын бодлого, иргэний оролцоо, эрх мэдлийн бүтэц, мэдээллийн тэгш бус байдал зэрэг практик үр дагаварт холбож судалдаг. Жишээ нь Европын холбоо болон Латин Америкийн орнуудад дэлгэрээд байгаа онлайн санал асуулгын платформууд нь олон нийтийн шууд оролцоог нэмэгдүүлэх боломжийг судлахад олон талт шинжилгээг ашиглаж байна. Энэ аргачлал нь технологийн интеграцчилсан нөлөөллийг ойлгох, бодлогын үр дүнг урьдчилан таамаглахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Хүснэгт 5. Улс төрийн философийн хүрээнд технологийн нөлөөллийг судлах олон талт шинжилгээ

Хэмжигдэхүүн	Нөлөөлөл	Жишээ	Давуу тал	Шүүмжлэл
Технологийн элемент	Иргэний оролцоо, засаглалын ил тод байдал, алгоритмын хяналт	Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, блокчейн	Технологийн нөлөөллийг олон өнцгөөс үнэлэх, онол, практикийн холболт бий болгох	Олон хэмжээт өгөгдлийг нэгтгэн үнэлэх төвөгтэй, төвөгтэй аналитик шаардлага
Нийгмийн болон соёлын	Жендер, угсаатны олон янз байдал, иргэдийн оролцоо	Онлайн санал асуулга, иргэдийн улс төрийн санаа, бодлыг судлахад чиглэсэн платформууд	Нийгмийн хүлээлт, эрх тэгш байдлыг үнэлэх боломжтой	Зарим тохиолдолд мэдээллийн төвлөрөл, тэгш бус байдлыг бүрэн шийдэж чадахгүй
Улс төрийн болон эрх зүйн	Эрх мэдлийн хуваарилалт, бодлогын үр нөлөө, олон улсын зохицуулалт	Иргэдийн санал цуглуулах платформууд, олон улсын уур амьсгалын гэрээ	Улс төрийн бодлого, засаглалын үр дүнг урьдчилан таамаглах боломж	Онол ба бодлогын төвөгтэй уялдаа шаарддаг
Технологийн хэрэглээ	Автоматжуулалт, алгоритмын шийдвэр гаргалт, мэдээллийн боловсруулалт	Хиймэл оюун ухаанд суурилсан шийдвэр гаргалт, блокчейн систем	Шийдвэр гаргалтыг хөнгөвчлөх, ил тод байдлыг нэмэгдүүлэх	Алгоритмын ил тод бус байдал, төвлөрөл, хяналтын дутагдал

Олон талт шинжилгээ нь соёл, жендер, угсаатны олон янз байдал, эрх мэдлийн хуваарилалт, мэдээллийн ил тод байдал зэрэг олон үзэл баримтлалыг нэгтгэдэг. Тухайлбал, хиймэл оюун ухааны алгоритм нь сонгуулийн мэдээллийг боловсруулахдаа ялгаварлан гадуурхах эрсдэлтэй бөгөөд энэ нь олон талт шинжилгээний тусламжтайгаар жендер, угсаатны эрх тэгш байдалтай холбогдуулан үнэлэгдэж, засаглалын бодлогод тусгадаг байна. Гэсэн хэдий ч олон талт шинжилгээний аргачлал нь зарим сорилтуудтай тулгардаг байна. Тухайлбал, олон хэмжээст өгөгдлийг нэгтгэн үнэлэхэд онол, техник, бодлогын төвөгтэй уялдаа шаардлагатай бөгөөд зарим тохиолдолд дүн шинжилгээ нь төвөгтэй, ойлгомжгүй үр дүн бий болгож болзошгүй юм.

Олон талт шинжилгээ нь орчин үеийн улс төрийн философийн технологийн нөлөөллийг олон өнцгөөс, интеграцчилан судлах, онол ба практик уялдаа холбоог бий болгох, олон нийтийн оролцоог үнэлэх гол аргачлал болж байна. Энэ нь зөвхөн онолын сургалт бус, бодит амьдрал дахь технологийн сорилтод нийцсэн, шинэлэг, харилцан уялдсан аналитик хүрээг бий болгох боломжийг олгож байгаа юм.

Улс төрийн философийн хүрээнд технологийн нөлөөллийг судлахад онол ба практикийн уялдааг ашиглах нь

Орчин үеийн улс төрийн философид онолын ба практикийн уялдаа (theoretical-practical integration)-нд тулгуурлан нийгэм, улс төрийн хөгжилд нь технологи хэрхэн нөлөөлж байгааг судлах аргачлал түгээмэл болоод байна. Энэ нь технологийн хөгжлийг зөвхөн онолын үүднээс тайлбарлах бус, засаглалын бодит механизм, иргэний оролцоо, эрх мэдлийн бүтэц, мэдээллийн тэгш бус байдал зэрэг бодит үр дагаварт холбон ойлгох аргачлал юм.

Онолын хувьд энэ нь улс төрийн эрх мэдлийн онол, либерализм, популизм, постлиберализм зэрэг үзэл баримтлалыг технологийн хөгжлийн үр нөлөөтэй уялдуулахыг шаарддаг. Жишээ нь популист хөдөлгөөнүүд цахим платформ дээр иргэдийн шууд оролцоог дэмжиж, засаглалын төвлөрлийг дахин үнэлэх боломжийг олгодог. Энэ нь онолын түвшинд эрх мэдлийн төвлөрлийг шүүмжлэх, практикийн түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхтэй холбогдоно. Нийгэм, улс төр, эдийн засгийн түвшинд технологи хэрхэн нөлөөлж байгааг судлахад их өгөгдөл, хиймэл оюун ухаан, блокчейн, цахим санал асуулга платформууд зэрэг нь судалгааны суурь эх сурвалж болдог. Жишээ нь Их Британи болон АНУ зэрэг улсад цахим санал асуулга, хиймэл оюун ухаанд суурилсан иргэний оролцооны платформууд нь засаглалын шийдвэр гаргалт, бодлогын үр нөлөөг урьдчилан таамаглах боломжийг бий болгож байгаа нь үүнийг илтгэдэг. Мөн блокчейн технологи нь төрийн үйлчилгээ, санхүүгийн болон тэтгэмжийн тогтолцооны ил тод байдал, хяналтын механизмыг сайжруулахад хэрэглэгдэж байна. Гэсэн хэдий ч онол ба практикийн уялдаа холбоо нь мөн л зарим нэг сорилтуудтай тулгарч байна. Тухайлбал, онолын түвшинд эрх мэдлийн төвлөрөл, алгоритмын ил тод байдал, олон нийтийн оролцооны асуудлыг нарийн тодорхойлсон боловч практик хэрэгжилтэд технологийн төвлөрөл, мэдээллийн эрх чөлөө, алгоритмын ялгаварлан гадуурхалт зэрэг асуудлууд саад болж байна. Мөн технологийн платформууд нь зарим тохиолдолд эрх мэдлийн төвлөрлийг дахин бий болгож, засаглалын ил тод байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Хүснэгт 6. Нийгэм, улс төрийн үйл явцад үзүүлж байгаа технологийн нөлөөллийг судлахад онол ба практикийн уялдаа (Theoretical-Practical Integration) ашиглагдаж буй байдал

Хэмжигдэхүүн	Тайлбар	Жишээ	Давуу тал	Шүүмжлэл
Онолын түвшинд	Улс төрийн эрх мэдлийн онол, либерализм, популизм, постлиберализм	Популист хөдөлгөөнүүд цахим платформ дээр иргэдийн оролцоог дэмжих	Эрх мэдлийн төвлөрлийг онолоор шүүмжлэх, олон үзэл баримтлалыг нэгтгэх	Практик түвшинд технологийн төвлөрөл, алгоритмын нууцлал зэрэг асуудлыг шийдэж чадахгүй
Практикийн түвшинд	Технологийн платформуудын бодит нөлөөлөл, засаглал, бодлого, иргэний оролцоо	Цахим санал асуулга, хиймэл оюун ухаанд суурилсан платформууд, блокчейн систем	Шийдвэр гаргалтыг хөнгөвчлөх, бодлогын үр нөлөөг урьдчилан таамаглах	Алгоритмын ил тод бус байдал, төвлөрөл, мэдээллийн тэгш бус байдал зэрэг сорилт үүсгэх
Интеграцчилсан байдлаар	Онолын үзэл баримтлал болон технологийн практик нөлөөллийг нэгтгэх	Популизм ба цахим платформуудыг холбосон судалгаа	Онол-практикийн холболт бий болгож, бодлого боловсруулахад чиглэсэн аналитик хүрээ	Системийн төвөгтэй байдал, олон хэмжээст өгөгдлийн нэгтгэлд төвөгтэй

Дээрх хүснэгтээс үзэхэд улс төрийн философийн хүрээнд технологийн нөлөөллийг судлахад онол, практикийн уялдаа нь онолын үзэл баримтлал, технологийн дэвшил, бодлогын хэрэгжилт, иргэний оролцоо, эрх мэдлийн хуваарилалт гэсэн олон түвшний харилцан уялдаа бүхий интеграцчилсан системийг бий болгодог нь харагдаж байна. Энэ нь зөвхөн онолын сургалт, судалгаа биш, бодит нийгмийн сорилтод нийцсэн, шинэлэг, холбогдсон аналитик хүрээ бий болгоход чиглэж байгаа юм.

Хүснэгт 7. Орчин үеийн улс төрийн философийн хөгжлийн үйл явц

Элемент	Тайлбар	Жишээ	Давуу тал	Шүүмжлэл
Дүгнэлт	Орчин үеийн улс төрийн философи нь уламжлалт онолыг өргөжүүлж, олон талт, интеграцчилсан, онол, практикийн уялдаатай болж, технологийн нөлөөллийг системтэй судалдаг	-	Шинэлэг, холбогдсон аналитик хүрээ бий болгох, бодлого, засаглал, иргэдийн оролцоонд хэрэглэх боломжтой	Олон хэмжээст шинжилгээ төвөгтэй, заримдаа ойлгоход хэцүү
Гол үзэл баримтлал	Нийтгч либерализм, Популизм, Постлиберализм, Глобал хандлага	-	Онолын суурь, практик хэрэглээ, технологийн интеграцчлалын ялгааг тодорхойлдог	Зарим үзэл баримтлалыг нэгтгэхэд төвөгтэй, практик хэрэгжилтэд хүндрэл үүсдэг
Технологийн нөлөөлөл	Хиймэл оюун ухаан, Big Data, блокчейн, цахим санал асуулга зэрэг нь засаглал, иргэдийн оролцоо, мэдээллийн ил тод байдалд нөлөөлдөг	АНУ, Их Британи дахь хиймэл оюун ухаанд суурилсан платформ, Европын онлайн оролцоо	Засаглалын ил тод байдлыг сайжруулах, бодлогын үр нөлөөг урьдчилан таамаглах	Алгоритмын төвлөрөл, мэдээллийн тэгш бус байдал, хяналтын дутагдал

Орчин үеийн улс төрийн философийн хөгжлийн гол онцлог нь уламжлалт философиос ялгаатай бөгөөд энэ ялгааг гурван үндсэн түвшинд авч үзэж болно. Эхнийх нь, орчин үеийн философи нь уламжлалт онолыг өргөжүүлэн олон талт, интеграцчилсан, онол ба практикийн харилцан уялдааг сайжруулж, технологийн нөлөөллийг системтэйгээр судалдаг гэдгийг онцолдог. Энэ нь зөвхөн онолын асуудал, судалгаа бус, төрийн бодлого боловсруулах, засаглалын ил тод байдлыг сайжруулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх боломжийг олгодог бөгөөд шинэлэг, харилцан холбогдсон аналитик хүрээ бий болгодог боловч олон хэмжээст шинжилгээ нь төвөгтэй, заримдаа ойлгоход хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгодог гэж зарим судлаачид үздэг.

Хоёр дахь нь гол үзэл баримтлалын түвшин нь орчин үеийн философийн хөгжлийг дараах дөрвөн чиглэл тодорхойлдог гэж үздэг. Үүнд нийтгч либерализм нь иргэний

эрх, жендер, соёлын олон талт байдал, экологийн асуудлыг нэгтгэн авч үздэг бол популист улс төрийн философи нь нийгмийн дээд давхрааныхан ба олон нийтийн хоорондын зөрчил, иргэдийн шууд оролцоог авч үздэг байна. Харин Постлиберализм нь уламжлалт либерализмын хязгаарлалт хийгээд технологийн нийгэм, улс төр, эдийн засагт үзүүлж байгаа нөлөөллийг онол ба практикын түвшинд нарийвчлан авч үздэг. Мөн глобал хандлага нь улс орны хязгаарлалтыг давж, дэлхийн хэмжээний асуудлыг онол болон бодлогод нэгтгэдэг. Эдгээр үзэл баримтлал нь хоорондоо онолын суурь, практик хэрэглээ, технологийн интеграцчлалын түвшнээр ялгаатай боловч орчин үеийн философийн хөгжлийг тодорхойлдог бөгөөд заримдаа эдгээр үзэл баримтлалыг нэгтгэхэд төвөгтэй, практик хэрэгжилтэд хүндрэл үүсгэх тохиолдол гардаг.

Гурав дахь нь технологийн нөлөөлөл нь орчин үеийн нийгмийн хөгжлийн практик хэрэглээг тодорхойлдог чухал хүчин зүйл гэж үзэх хандлага юм. Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, блокчейн, цахим санал асуулга зэрэг технологи нь засаглалын бүтцэд хийгээд иргэдийн оролцоо, мэдээллийн ил тод байдалд шууд нөлөө үзүүлж байна. Жишээ нь АНУ, Их Британи дахь хиймэл оюун ухаанд суурилсан платформууд болон Европын онлайн оролцооны систем нь засаглалын ил тод байдлыг сайжруулж, бодлогын үр нөлөөг урьдчилан таамаглах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгддэг. Гэсэн хэдий ч алгоритмын төвлөрөл, мэдээллийн тэгш бус байдал, хяналтын дутагдал зэрэг нь практик хэрэглээнд хүндрэл учруулж болохыг харуулж байна.

Дүгнэлт

Орчин үеийн улс төрийн философийн хөгжлийн үйл явц нь уламжлалт улс төрийн философиос үндсэндээ ялгаатай бөгөөд гол ялгаа нь олон талт, интеграцчилсан, онол ба практикийн уялдаа, технологийн хөгжил, түүнээс үүдэлтэй өөрчлөлтийн нийгэм, улс төр, эдийн засагт нөлөөлж байгаа байдлыг системтэйгээр судлах зэрэгт оршдог.

Уламжлалт улс төрийн философи нь эрх мэдэл, төрийн бүтэц, хүний эрх, засаглалын асуудалд илүү төвлөрдөг байсан бол орчин үеийн улс төрийн философи нь эдгээр суурь ойлголтыг өргөжүүлэн технологийн хөгжил, түүнээс үүдэлтэй өөрчлөлт, олон нийтийн оролцоо, соёл, жендер, угсаатны олон талт байдал, глобал харилцаа зэрэг олон хүчин зүйлтэй нэгтгэн авч үзэж байна.

Нийгэм, улс төр, эдийн засаг дахь технологийн нөлөөлөл нь орчин үеийн улс төрийн философийн үндсэн асуудлуудын нэг бөгөөд хиймэл оюун ухаан, их өгөгдөл, блокчейн, цахим платформ зэрэг нь засаглалын бүтэц, иргэдийн оролцоо, эрх мэдлийн хуваарилалт, мэдээллийн ил тод байдалд шууд нөлөө үзүүлж байна. Үүнтэй холбогдуулан олон талт шинжилгээ, онол ба практикийн уялдаа зэрэг нь улс төрийн философийн судалгааны шинэ аргачлал болж, технологийн хөгжлийг интеграцчлалыг онолын үзэл баримтлалтай уялдуулан судлаж эхэлжээ. Энэ нь зөвхөн онолын асуудал, судалгаа бус, төрийн бодлого боловсруулах, засаглалын ил тод байдлыг үнэлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг практик хэрэглээнд маш чухал ач холбогдолтой нь судалгаагаар нотлогдоод байна.

Орчин үеийн улс төрийн философийн гол үзэл баримтлалууд болох нийтэч либерализм, популист улс төрийн философи, постлиберализм, глобал хандлага зэрэг нь хоорондоо онолын үндэс, технологийн интеграцчлал, практик хэрэглээний түвшнээр ялгаатай боловч орчин үеийн улс төрийн философийн хөгжлийг тодорхойлж байгаа юм. Нийтэч либерализм нь нийгмийн олон талт байдлыг нэгтгэн авч үздэг бол популист улс төрийн философи нь иргэдийн шууд оролцоо, нийгмийн дээд давхрааны ба олон нийтийн хоорондын зөрчлийг авч үздэг. Постлиберализм нь технологийн нөлөөллийг онол ба практикын түвшинд нэгтгэн хиймэл оюун ухаан

болон цахим платформыг ашиглан засаглалын ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн асуудлыг ихээр хөнддөг бол глобал хандлага нь үндэстэн угсаатан, улс орны хязгаарлалтыг давж, дэлхийн хэмжээний асуудлыг онол болон бодлогод нэгтгэдэг байна. Гэсэн хэдий ч орчин үеийн философийн хөгжил нь зарим тулгамдсан асуудлуудтай тулгардаг. Эдгээр нь технологийн төвлөрөл, алгоритмын ил тод бус байдал, мэдээллийн тэгш бус байдал, олон хэмжээст шинжилгээний төвөгтэй уялдаа холбоо зэрэг юм. Мөн олон үзэл баримтлалыг нэгтгэх оролдлого нь заримдаа төвөгтэй, ойлгоход хэцүү, онол ба бодлогын уялдааг бүрэн хангаж чадахгүй байх эрсдэлтэй юм.

Эндээс үзэхэд, орчин үеийн улс төрийн философи нь уламжлалт улс төрийн философийг өргөжүүлэн олон талт шинжилгээ, технологийн интеграцлал, онол, практикийг уялдуулан зөвхөн онолын сургалт, судалгаа бус, нийгмийн бодит үйл явцад нийцсэн, шинэлэг, харилцаа холбоо бүхий аналитик хүрээ болж хөгжиж байна. Энэхүү хөгжлийн үр дүнд улс төрийн философи нь орчин үеийн засаглалын асуудлыг судлах, олон нийтийн оролцоо, технологийн хөгжил, түүнээс үүдэлтэй өөрчлөлт, глобал асуудлыг нэгтгэн үнэлэх чухал хэрэгсэл болж байна гэж үзэж болно.

Ном зүй

Appiah, K. A. (2006). *Cosmopolitanism: Ethics in a world of strangers*. W. W. Norton & Company.

Beck, U. (2006). *The cosmopolitan vision*. Polity Press.

Dryzek, J. S. (2020). *The politics of the earth: Environmental discourses* (3rd ed.). Oxford University Press.

Etzioni, A. (1995). *New communitarian thinking: Persons, virtues, institutions, and communities*. University of Virginia Press.

Etzioni, A. (1998). *The new golden rule: Community and morality in a democratic society*. Basic Books.

Floridi, L. (2021). *The ethics of information*. Oxford University Press.

Galston, W. A. (1991). *Liberal purposes: Goods, virtues, and diversity in the liberal state*. Cambridge University Press.

Held, D. (2020). *Global transformations: Politics, economics and culture*. Stanford University Press.

Miller, D. (2007). *National responsibility and global justice*. Oxford University Press.

Mouffe, C. (2019). *For a left populism*. Verso Books.

Norris, P., Inglehart, R. (2019). *Cultural backlash: Trump, Brexit, and authoritarian populism*. Cambridge University Press.

Nussbaum, M. C. (1997). *Cultivating humanity: A classical defense of reform in liberal education*. Harvard University Press.

Rawls, J. (1971). *A theory of justice*. Boston: Harvard University Press.

Sandel, M. J. (1998). *Democracy's discontent: America in search of a public philosophy*. Belknap Press.